

**Шашин шүтлэгийн тусгал хийгээд монгол
“Гэсэрийн тууж”-ийн төлөвшсөн цаг үе**

*Эрдэнэбилэг (БНХАУ
Баруун Хойтын Үндэстний Дээд сургууль)*

“Гэсэрийн тууж” дахь бөөгийн шашин хийгээд бурханы шашны нөлөө тусгал нь тус туужийн цаг үеийн асуудлыг тодорхойлоход зохих үйлдэлтэй. Хэлэлгээн үгүй зөвхөн шашны нөлөө тусгалаар бүх “Гэсэрийн тууж”-ийн төлөвшсөн цаг үеийг зөв оновчтой тодлон тодорхойлж чадахгүй юм. Гэвч нийгмийн үзэл ухамсарын хэлбэр болсон шашин шүтлэг нь тухайн нийгмийн хүмүүсийн үзэл санааг тусгаж чадах гол нэгэн баримт болно.

Язгуурын Монголчууд бөөгийн шашныг шүтээнээ болгож байснаас биш, бурханы шашныг шүтээнээ болгож байсангүй. Бурханы шашин (ламын шашин) монголжуу овог аймаг ястаны дэмжилгээр хожуу сүүлд уламжлан орж ирсэн зүс буруу шашин болно. Тэгвэл Монголчууд чухам аль үеэс эхэлж бурханы шашин (дамын шашин)-ыг төрийн шашин болгон ихээр шүтэж тахисан буй гэвэл, гарт олдсон түүх шастирыг урвуулж үзвэл, Хубилай сэцэн хааны үеэс эхэлсэн байлаа.

Нэг. Бурханы шашин Монголын өндөрлөгт нэлээд эрт уламжлагдан орсныг түүх сударт тэмдэглэн үлдээсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эртний Монголын өндөрлөг дээр оршин амьдарч байсан Хүннү, Сяньби, Нирун, Уйгур, Монгол зэргийн олон улс аймгийн үед бурханы шашныг адил бус хэмжээгээр шүтэн тахиж байжээ.

Монголын түүхч Амар “Монголын товч түүх” гэх номдоо “...Хүннү нар бол бөө мөргөлтэй бөгөөд онгодыг эрхэлж тэнгэр, нар сар, газар дэлхий хийгээд орчлон ертөнцөд тоо томшгүй хий биет алман (албин) чөтгөр байдаг хэмээн итгэдэг байсан бөгөөд ертөнцийн амьдрал бүхий бодосыг бэлгэдэж тахихаар байгуулсан олон сүм нь Ордосын нутгаас өмнө Хатан голын эрэг дээр нэлээд сүүлд хүртэл байсан хэмээхээс гадна, зарим түүхэнд Хан улсын цэргүүд нь Хүннү цэргийн авч явсан бурханы хөргийг олсноор Хан улс бурханы шашин шүтэх болсон хэмээснийг үзвэл, Хүннү нар бас бурханы шашин шүтэж байсан мэт

болно"¹ гэж Хүннүчүүд бурханы шашныг шүтэж байсныг тодорхойлон үзүүлжээ.

Бас Дармадалаа гүүш "Монгол орноо дээдийн ном дэлгэрсэн ёсон" хэмээх зохиолдоо "...Монгол оронд дээдийн ном эх олсон нь маш их урьд цагт болно. Хятадын Хан улсын Ү хаан (5-р хаан нь, аргын тооллын өмнөх /56-140/ оны хооронд байсан Жин Ди болно. Д. Ц)-ы үед Монголын эд хогшлын дотроос бурханы хөрөг олсон гэж номлосон байна. Тэр үед Монгол оронд бурханы хөрөг байсан учраас олдсон. Хэрэв байхгүй бол юугаа олох буй" гэсэн байна.² Энэ талаар Оросын эрдэмтэн Н.Я.Бичурин, Дорж Банзаров нар бичихдээ: "...бурханы шашин зургадугаар зууны сүүлийн хагаст Түркийн Тобоу хааны үес анх удаа тал нутагт албан ёсоор дэлгэрчээ" гэснийг С.В. Киселев "Өмнөд Сибирь орны эртний түүх"-дээ "...Тобоу хаан 572 онд бурхан багшийн сургаалыг Монгол оронд дэлгэрүүлсэн"³ гэж улам нэг алхам нарийган өгүүлжээ.

Уйгур аймаг 8-9-р зууны үед Монголын өндөрлөгийг ноёрхож байх хугацаандаа шашин шүтлэг, үсэг бичиг зэрэг талаар Монголчуудад ихээр нөлөөлсөн байдаг. Монгол улсын нэрт эрдэмтэн, академич Цэрэнсодном багшаас "Монгол нутагт оршин сууж байсан Түрк хэлтэн нарын дотроос эрт дээр цагаас бурханы шашинд орсон ард түмэн болбоос уйгурчууд юм"⁴ гэж хэлсэн байдаг.

Үүнээс гадна Амар "Монголын товч түүх" гэх номдоо "...Согд хэмээх улс болбоос мөн баруун зүгээс ирж тэр цагт Уйгурын нутагт худалдаа хийж байснаас гадна хоёр анги шинэ шашныг дэлгэрүүлжээ. Энэ нь Шагжамунийн шашин ба нөгөө нь мөн баруун зүгээс ирсэн маань хэмээдэг шашин маанийн шашин нь одоо хаа ч үлдсэнгүй. Гагцхүү Монголд уул тахих, гал тахих нь хоцорсон хэмээдэг болой. Уйгур, Түрк, Монголчуудад тэр цагт цөм бөөгийн шашинтай байсан боловч Согдын багш нар Монголын нутагт сүм дуган барьж Шагжамунийн шашныг дэлгэрүүлжээ"⁵ гэв.

Чингис хааны зөвлөгч, бичиг соёлын явдлын түшмэл Тататунга бол Найман аймгаас олзлогдож ирсэн хүн, тэр эртний уйгуржин үсгийг мэддэгээр барахгүй уйгуржин үсэгтэй тамгыг авч ирсэн сураг занги байдаг. Найман аймаг бол Уйгурын нөлөөг шууд хүртсэн аймаг болно.

Нөгөө нэг баримт бол 20-р зууны эхний үеэр Турфанаас олсон эртний дурсгалт бичгийн олонхи нь бүр Уйгур хэлээр бичигдсэн бурханы шашны ном судар болно. Энэ бол Монголын өндөрлөгт бурханы шашин дэлгэрсэн анхны шат үе болно. Энэхүү анхны үед бурханы шашин

¹ (Монгол) Амар, Монголын товч түүх, кирилл үсгээр, Улаанбаатар, 1989 он, 39-75-р тал.

² (Монгол) Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, кирилл үсгээр, Улаанбаатар, 1997 он, 65-66-р тал.

³ Пүрэв, Монгол бөөгийн шашин. Улаанбаатар, 1999 он, 41-р тал.

⁴ (Монгол) Д.Цэрэнсодном, Монголын бурханы шашны уран зохиол, кирилл үсгээр, Улаанбаатар, 1997 он, 62-р тал.

⁵ (Монгол) Амар, Монголын товч түүх, кирилл үсгээр, Улаанбаатар, 1989 он, 39-75-р тал.

"Гэсэрийн тууж"-ийн агуулга, үзэл санааг нөлөөлж чадахгүй ч гэсэн боломжийг олгож өгсөн хамгийн анхны бололцоот нөхцөл болно.

Хоёр. Бурханы шашин (ламын шашин) Монголын өндөрлөгт али эрт орж ирсэн боловч шууд Монгол улстай харьцаа үүсгэсэн нь 13-р зууны үе болно. Гэвч бүх Монголчуудын үзэл санааг эзэмшиж хөгжил тархлаа олж арай чадсангүй билээ. Тухайн үед Чингис хаан зөвхөн өөрийн улс төрийн зорилгоос болж, Төвдийн Сажа сүмийн их лам Гунгаанинботай харьцаа авалцаж байсан сураг чимээ байдаг бөгөөд Чингис хаанаас Мөнх хааны үед эл зүйлийн шашинд бүр адил тэгшээр хандах төрийн бодлого авч байсныг түүх сударт тодорхой тэмдэглэж байдаг.

"Монгол Төвдийн ламын шашны хооронд жинхэнэ харьцаа үүссэн нь 1236 оны хэрэг болно. Годан (Өгэдэйн хоёрдугаар хөвгүүн)-ы харьяат улсад уул нь баруун Сиянд харьяалагдах газар жич одоогийн Гансу, Хөхнуур дахь хэсэг Төвд үндэстний газар нутаг багтаж, ордноо Лиан Эү (Гансу мужийн Эү Ви Хот)-д байгуулав. 1238 онд Монгол хаант улс гурван замаар Өмнөд Сүн улсыг довтолж, Годан цэргээ дагуулаад одоогийн Гансу мужийн Тянь Шүй, Лүн Шигээс өмнөш (урагш) орж дараа жил нь Цайтыг довтлов. 1239 онд Годанаас их жанжин Дорданайхуг томилон Төвдийг төвшитгөв.

Дорданайхугаас Годанд захидал илгээж Төвдийн шашин суртахууны байдлыг нарийн танилцуулав. 1244 онд Годан нутагтаа буцсаны дараа Дорданингүг томилж Сажа бандидад Сажа захидал ба бэлэг хүргүүлэн Лиян Худ урин залав.

Захидалдаа "...Мөнх тэнгэрийн хүчинд их хааны зарлиг Сажа бандида Гунгаажалцанбалсанбуу та мэдэх болов уу?, хааны зарлигаар би эцэг эхийн энэрэл ачийг хариулахын тусад зам мөрийн тотгорыг арилгаж, нэгэн ламыг сонгох хэрэгтэй болов. Ийнхүү таныг сонгосон тул зовол зүдүүрийг тэвчин хүрэлцэн ирээрэй. Хэрэв чи насан ахиснаар шалтаг болгож эс ирвээс, шашны хуулийг сурах үеийн амлалтаа зөрчих биш үү. Тэгвэл би чамаар баруун орны лам хуврагийг захируулмуу. Чамд шагнаж өгөх эд болбоос цагаан алт таван хэсэг, зургаан мянган мөхлөг сувд шигтгэсэн орхимж, шар хэмэрлэг орд ханжаар, хоёр зүйлийн гутал, таван өнгийн хэмэрлэг хорин ороолтыг Жодорс, Гонбанжидарма хоёроор хүргүүлэв"⁶ гэжээ. Энэ үед голдуу улааны шашныг шүтэж байжээ. "Гэсэрийн тууж"-д "...би баруунтаа мөнх газраас ирлээ би. Хар манжилгат Гармагийн өгсөн зуун найман хив мяндсан зангиа билээ. Зүүдэг буюу даа гэв. Эвүү их ламын өгснийг юу хийж үл зүүм. Аль ац гэв"⁷ гэж 13-р зууны дунд үеэр амьдарч байсан Төвдийн ламын шашны бусад бүлгийн түрүү Гарма ламыг дурдаж, шарын шашны түрүү болох Зонхов, Далай лам зэрэг хүний нэрийг огт дурдсангүй байна.

Эдгээр нь санамсаргүй гэнэтийн тохиолдол биш, харин "Гэсэрийн тууж" тухайн үед нэгэнт бий болон төлөвшиж ард иргэдийн дунд нийдэм дэлгэрсний бодот гэрч мөн. 1256 онд Мөнх хааны уулзалт гэх зарлигийн

⁶ Боржигин Жаргал, Монгол төр шашны түүхийн өгүүлэмж, Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн хороо, 1996 он.

⁷ "Гэсэрийн тууж", Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо, дээд дэвтэр, 1955 он, 164-р тал.

бичгийг олж Хархорум хотод хүрч, Мөнх хаан ба Аригбухтай уулзаж, Мөнх хааны сайшаал хүрээллийг олсон тул хаанаас Гарма ламд алтан тамга хас эрдэнэсийн зүйлийг шагнаснаар барахгүй бас нэгэн алтан хөвөөт хар өнгөт ламын малгайг шагнасан байна. Үүнээс хойш Гармагийн хар малгайтын бүлэг гэж дуудах болсон гэдэг.

Ц.Дамдинсүрэн "Монгол уран зохиолын тойм" (дээд дэвтрийн 521-р тал)-доо 13-р зууны үед "Панчатантра"-гийн нэг хувилбар "Галила Димнагийн үлгэр" хэмээхийг перс хэлнээс монгол хэлэнд орчуулан Мөнх хаанд уншуулж байсан мэдээг Зөвлөлтийн эрдэмтэн Владимирцов "Панчатантраас авсан монгол өгүүлэгийн цоморлиг" хэмээх номдоо бичсэн билээ гэснээс үзэхэд, Монголчууд аль эртнээс харийн соёлын охь шилдэгийг хүлээн авч, өөрийн үндэстнийхээ соёлоо өрнүүлэн хөгжүүлж, шинэ соргогийг эрхэмлэн, шинэ соргогийг урлан бүтээсээр ирсэн үндэстэн гэдгийг давхар гэрчилж байна. Мөнх хаан (1259 он) нас барж, Хубилай 1260 онд хаан сууринаа сууж, Төвдийн лам Пагваг залж ирээд "улсын багш" хэмээх цол өргөмжилж, "хааны багш" болгоод хас тамга шагнажээ.

Улс төр, аж ахуй, шашин шүтлэгийн талаар бүр давуулаг хүчинтэй байсан учраас Хубилай сэцэн хаан юуны урьд Пагва ламыг өргөмжилж ламын шашныг нь Монгол оронд хууль ёсоор жинхэнээр дэлгэрүүлсэн байна. Энэ бол Монгол оронд бурханы шашин (улааны шашин) дэлгэрсэн хоёрдугаар шат үе болно. Гэвч энэхүү шашин нь ард түмний дунд нийдэм дэлгэрэн хөгжиж чадсангүй. Зөвхөн Монголын дээд давхаргатны дотор шүтэгдэж байсан юм.

Тухайн үеийн Монголчууд баларлаг шашин-бөөгийн шашнаа шүтэж, ламын шашныг дэмий шүтэхгүй байв. Учир нь, тухайн үед, улс гүрэн энх төвшин ард иргэдийн амьдрал энх тайван байсан бөгөөд Хубилай сэцэн хаан ч Түмэдийн Алтан хаан мэт хатуу зарлиг буулгаж хар албаар ард түмнийг албадан шаардаж шүтүүлсэнгүй. Зөвхөн Монгол Төвд хоёр үндэстний бүлгэмдлийг улам нэг алхам нягтруулж сайжруулах улс төрийн үүднээс Төвдийн ламын шашныг шүтсэн төдийгөөс биш, яг үнэн сэтгэлээсээ бишрэн шүтэж дэлгэрүүлсэн гэж хэлэхэд хүчиртэй юм.

Нөгөө талаар, Хубилай сэцэн хаан улсын гол гол тахилга болоход, бөөгийн шашнаар тахилгаа явуулдгаас нь үзвэл, бөөгийн шашныг ламын шашнаас илүү бишрэн шүтэж байсныг тодорхойлж байна. Дахиад хэлбэл, тухайн үед Зонхов ламын шашныг өөрчилж шарын шашин болгоогүй, зөвхөн ламын шашин байсан юм. Иймээс, бурханы шашин (ламын шашин) нэвтрэн орсон явдлыг хожмын шарын шашин Монгол оронд дэлгэрсэн явдалтай адилтгахын аргагүй юм.

1368 онд Жү Юан Жан их цэрэг дайчлан Бээжин хотыг эзэлсэнд Тогоонтөмөр хаан хэсэг цэргээ дагуулж, Монголын өндөрлөгт очсоны хойно Монголын дээд давхаргатан нар ч ламын шашныг дэмий шүтэхээ больж, тэрхүү шүтээн болж байсан лам хуврагуудын зарим нь Төвддөө буцсан байна. Иймээс ордон ба дээд давхаргатны дунд дэлгэрч агсан ламын шашин төрийн ялагдлыг дагалдан Монголчуудын дунд нөлөө тусгал нь буурчээ.

Энэ үеэс эхэлж, Монголын дээд давхаргатагч нар өвөг дээдсийн шүтэж тахиж байсан бөөгийн шашнаа дахин тахиж болжээ. 16-р зууны үе хүрэхэд нийгмийн байдалд их хувиралт гарчээ. Даруй Түмэдийн Алтан хаанаар толгойлуулсан нэг хэсэг хан ноёд шарын шашныг шүтэхийг хүсэмжилж, 1578? оны 5 сарын 15-ны өдөр Алтан хаан Цавчаал сүмд Монгол, Хятад, Төвд, Уйгур зэрэг арван түмэн хүн оролцсон их цуглаан дээр Содномжамцад "Далай лам" хэмээх цол өргөмжилсөн бөгөөд Пагва ламтай адилтгаж, өөрийн биеэ Хубилай сэцэн хааны бүрэлбаа хэмээн зүйрлэж, Монгол оронд шарын шашныг бүх талаар дэлгэрүүлэхийг чанга шаардаж хатуу цааз дүрмийг тогтоосон байна.

Энэ бол Монгол оронд бурханы шашин (шарын шашин) дэлгэрсэн гуравдугаар шат үе болно. Нэн ялангуяа, 1640 онд тогтоосон "Ойрад цааз"-д бөөгийн шашныг шүтэхийг эрс цаазалсан байна. Жишээлбэл: "Ойрад цааз"⁸-ийн 5-р зүйлд, шашны тус лам нарын үйл аймгийг алж талж авбаас зуун хуяг, зуун тэмээ, мянган адуу авах; 14-р зүйлд, цорж нарыг дайрахул таван ес авах, гэлэнгүүдийг дайрахул гурван ес авах, бандийг нь дайрахул, чавганц нарыг дайрахул тав авах; 109-р зүйлд, удган бөөг хэн хүн авч явахул уригч хүний морийг нь ав, ирэгч удганы морийг нь ав, үзэж байж хүн эс авахул түүний морийг нь ав, онго хэн хүн үзэхүл авах болов. Эзэн нь булаагдаж эс өгөхүл морийг нь ав, 16-р зүйлд, лам нар банди нараас улаа унахул нэг үхэр ав... гэх мэтээр бөөгийн шашныг цаазалж, шарын шашныг дэлгэрүүлэх арга хэмжээг авсан байна. Түмэдийн Алтан хаан бас бөөгийн шашныг хориглон хүчингүй болгож, бурханы шашныг дэлгэрүүлэх хууль цааз тогтоосон байна. Даруй "...бөөгийн онгоны дүрс хөргийг эрхбиш галдах хэрэгтэй. Зөрчигсдийг чангаар шийтгэнэ. Амьтны амийг тасалж, мах цусаар тахихыг зогсоох хэрэгтэй. Зөрчигсдийг алсан малын тооны арав дахинаар торгоно. Жилд гурван удаа онгон шүтээнээ мал унаа алж шүтдэг ёсыг үгүйгэж, онгодын оронд нь зургаан морьт Махагалын биеийн хөргийг нэжгээд тахиж ба түүнд гурван цагаан (сүү, эззгий, айраг)-ы тахилаас бусад мах цусаар огт тахиж болохгүй"⁹ гэжээ.

Ойрад Монголчуудын дунд шарын шашныг дэлгэрүүлж хөгжүүлэх ажилд Зая бандида Намхайжамц мөн ч чухал үйлдийг үзүүлж тэр бөөгийн шашинтай эвлэршгүй тэмцэл явуулж байсныг "...та нар хэн хэрэв ард олны дунд ямар нэгэн хүн зориг мэдэн онгон шүтээн шүтэж байхыг олж харвал онгон шүтээнийг нь галдаж хаяхаар үл баран морь унаа болон хонийг нь хураан автугай. Бөө болон удганыг залж тахилга хийгсдийг сүм хийдийн талаас тэдний морь унааг нь хураан авч, нохойн баасаар тахилга зул хийлгэтүгэй"¹⁰ гэж доорхи лам хуврагууддаа зарлиг буулгаж байжээ. Үүнээс гадна, Алтан хаанаас сүм хийд байгуулж, ном судар орчуулах, сахил санваарт найдах зэрэг бодтой шийдвэр зэргийг баталжээ.

⁸ Дорнотивийн харьцуулан тайлбарласан "Ойрад цааз", Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо, 1985 он.

⁹ Боржигин Жаргал, Монгол төр шашны түүхийн өгүүлэмж, Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн хороо, 1996 он.

¹⁰ Зая бандидын намтараас дам эшлэв.

Үүнээс хойш бөөгийн шашныг шүтэхийг эрс цаазалж, багаж зэвсгийг нь бүгдийг шатааж, зарим бөө удгануудыг алсан явдал ч гарчээ. Иймэрхүү хатуу чанга цааз хорионы доор бөөгийн шашин арга буюу сөнөж мөхөх замдаа орж, шарын шашин шүтлэг бишрэлийн талаар давуулаг байрыг эзэлж, Монгол оронд угийн байсан баларлаг шашин-бөөгийн шашныг нийдэм орлосноор үл барам, улс төр, аж ахуй, соёл боловсрол зэрэг бүх талаар Монголын нийгэмд шууд нөлөөлсөн байна.

Дээрхи байдлаас үзвэл, Түмэдийн Алтан хаан зэрэг хүмүүсийн зарлиг цааз болон "1640 оны Халх Ойрадын цаазын бичиг" батлагдан тогтоогдохоос өмнө бурханы шашин (ламын шашин)-ы нөлөө Монголын ард түмний үзэл ухамсарыг бүх талаар эрхшээх бололцоо дэмий байхгүй. Ялангуяа ард түмний үзэл санаа хүсэл эрмэлзлийг зөв оновчтойгоор шууд тусган харуулж байдаг ардын аман зохиолын нэгэн төрөл "Гэсэрийн тууж"-ийн агуулга, үзэл санаанд ихээр нөлөөлж нэн ч чадахгүй юм. Харин бөөгийн шашин ард түмний үзэл ухамсарыг ноёрхож голлох байрыг эзэлж байсан нь үнэн хэрэг. Гэхдээ бурханы шашин Монгол оронд дэлгэрсэн анхны шат үе ба хоёрдугаар шат үед бага сага нөлөөлснийг бас үгүйсгэж болохгүй юм.

Гурав. Тэгвэл бөөгийн шашин "Гэсэрийн тууж"-д чухам аль үед тусгалаа олох бололцоотой буй гэдэг асуудлыг шинжиж үзье.

Бөөгийн шашны нөлөө "Гэсэрийн тууж"-д чухам аль үед шингэн орсон гэдэг асуудлыг нэг л дээр оновчтой тогтоон хэлэхэд хүчиртэй. Юу болсон ч 1640 он хүртэл Монголчууд бөөгийн шашныг адил бус хэмжээгээр шүтэн тахиж байсан юм. 1640 онд "Ойрад цааз"-ыг тогтоосноос хойш бөөгийн шашныг эрс цаазалсан учраас шүтэж тахиж хүн ч аяндаа цөөрч, зарим бөө нар шарын шашны ёс номлолыг өөрийн шашиндаа уусган шингээж, зарим нь шууд шарын шашинд орон өгөх зэрэг харилцан уусалцсан нарийн будлиантай байдал илэрч, бөөгийн шашин нь шарын шашны энэхүү хүчтэй дайралтын доор явах тутам нөлөө тусгалаа алдаж, доройтол мөхлийн замдаа орж эхэлсэн байна.

Х.Буянбат багш "Монголын бөөгийн шашны учир" гэх номдоо 16-р зууны далаад оноос 20-р зууны эхэн үеийг "Монгол бөөгийн шашин усталын үе"¹¹ хэмээн үечилсэнтэй яв цав нийцэж байна.

Нөгөө талаар ламын шашны тус биеийн зарим онол номлол нь Монгол оронд уулаасаа байсан бөөгийн шашныхаас хол бүрэн төгөлдөр бөгөөд итгүүлэх хүчээр их байсан байна. Тухайн үед Монголын эл аймаг бүлэг хоорондоо тасралтгүй дайн байлдаан хийж, Монголын ард түмний амьдралд туйлын их гашуун зовлонг авчирч байсан учраас ламын шашны тэдгээр төрөл арилжиж бурхан болж, хүн амьтныг алахгүй, өршөөл журам, энэрэл хайр, үйлийн үр хувь барилдлагын тухай сургаал нь Монголчуудын оюун тархинд нь гүн суугдаж, бөөгийн шашин уулын итгэл бишрэлээ алдаж эхэлжээ.

Иймээс 1640 оноос хойно "Гэсэрийн тууж"-д бөөгийн шашны нөлөө тусгал орох бололцоо бараг байхгүй. Харин үүнээс өмнө бөөгийн шашны нөлөө тусгал шингэн орох нь зүй ёсны хэрэг билээ. Цаашид

¹¹ Х.Буянбат, Монголын бөөгийн шашны учир, Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн хороо, 1985 он.

бөөгийн шашин нь "Гэсэрийн тууж"-ийн эхлэн соёолж буй болохыг дагалдан шингэн нэвтэрсэн байж ч болох юм. Зарим буйд бөглүү газар орноор бөөгийн шашин ба түүний зан үйл сүүлийн үе болтол уламжлагдан шүтэгдэж байсан боловч тэр нь бүх "Гэсэрийн тууж"-ийн агуулга үзэл санаанд нөлөөлөх бололцоо арай байхгүй юм.

Дөрөв. "Гэсэрийн тууж"-д бурханы шашин буюу шарын шашны нөлөө тусгал чухам аль үеэр шингэн нэвтэрсэн буй гэвэл, Монголын өндөрлөг дээр бурханы шашин дэлгэрсэн тэр цаг үеэс эхлэн "Гэсэрийн тууж"-д адил бус хэмжээгээр нөлөөлж эхэлсэн бололтой. Учир нь, ардын аман зохиолд тогтворт шинж байхгүй, хэзээд хөдлөнги байранд оршиж, эл нийгэм төрийн байдал ба хүмүүсийн үзэл санааг цаг ямагт үгүй хүлээн байдаг тул "Гэсэрийн тууж"-д эл үеийн шашин шүтлэгийн нөлөө тусгалыг шингээн авсаар иржээ.

"Гэсэрийн тууж" хэдийгээр 16-р зуун болоход нэгэнт хэвшин төлөвшсөн боловч сүүлчийн үеийн шарын шашны хүчтэй дэлгэрлийн дунд тэдгээр шарын шашинтан нар өөрийн үзлээ санаачлагатай ба санаачлагагүйгээр "Гэсэрийн тууж"-ийн хажуу хавиргад нь наалдуулан шингээсээр ирсэн байна. Өөрөөр хэлбэл, 1578 онд Алтан хаан Төвдөөс Содномжамцыг залж ирээд "Далай лам" хэмээх цолыг өргөмжилж, шарын шашныг эхлэн дэлгэрүүлж эхэлжээ.

16-р зууны сүүлч 17-р зууны эх болоход шарын шашин уламжлахын явцад монгол соёл зан үйлтэй аажим аажмаар идээшин дасч, Монгол оронд бүх талаар дэлгэрэн хүмүүсийн үзэл ухамсарт адил бус хэмжээгээр нөлөөлснөөс "Гэсэрийн тууж" хайлагчид нь туужийг хайлах явцдаа шарын шашны агуулгыг хар албаар нэмж оруулсан юм.

Үүнд ноёрхогч анги өөрийн улс төрийн зорилгоос болж, санаачлагатайгаар нэмж оруулсан зүйлс ч буй. Тухайлбал, 13-р зууны үед зохиогдсон "Монголын нууц товчоон"-д хуудас нээмэгц (1-р зүйлд) Чингис хааны үндэс язгуурыг "Чингис хааны язгуур дээд тэнгэрээс заяат Бөртэ чоно ажгуу. Гэргий нь Хуа Марал аж. Тэнгис гаталж ирэв" гэж тодорхой тэмдэглэж байхад, шарын шашин Монгол оронд дэлгэрсний дараа бичигдсэн "Болор толь"-д "...тэр богд Чингис хааны уг язгуурыг мөрдөн ирвээс, Энэтхэгийн Шагжагийн язгуурын уг нь анх галавын үед Замбутив дээр эхлэн суусан Махасамади хааны язгуур тэр бөлгөө" гэж зориуд холбон өөрчилж бичжээ.

Энэ даруй шарын шашинтан нараас Чингис хааныг бурханы шашны үүссэн Энэтхэг Төвдөөс гаралтай гэдэг шашны номлолоор өөрийн шашнаа бүх Монгол оронд дэлгэрүүлэх үүднээс тусгайлан зохион гаргасан зүйл болох нь маш тодорхой. Ангит нийгэмд "ноёрхогч ангийн үзэл санаа бол тус бүрийн цаг үедээ бүр ноёрхох байрыг эзэлдэг үзэл санаа мөн. Даруй нийгмийн бодосын хүчний ноёрхох байрыг эзэлж байдаг анги нь тус нийгмийн зориг санааны талд ч ноёрхох байрыг эзлэх болно"¹².

¹² "Цөөн тоот үндэстний ардын аман зохиолын тойм"-оос дам эшлэв. Хятад хэвлэл.

Иймэрхүү ангит нийгэмд амьдарч байгаа хөдөлмөрчин ард түмний байр суурь, орчин тойрон нь туйлын дорой буурьтай тул тэдний шилдэг үзэл санаа зан чанар ноёрхогч ангийн дарлал доор хүчин хөгжиж чадахгүй, мөлжигч анги эд бодсын талаар л ард түмнийг мөлжихөөр барахгүй, үзэл санааны талаар бас ард түмнийг ноёрхож байсан учраас хөдөлмөрчин түмний үзэл санаа ноёрхох ангийн үзэл санааны нөлөөг хүртэхгүй байж чадахгүй юм. Ийм нэгэн цаг үед шарын шашныг "Гэсэрийн тууж"-д санаачлагатайгаар шингээн оруулж, ардын үзэл санааг минчрүүлэхээр оролдсоны бодот тусгал болно.

Нөгөө талаар, "Гэсэрийн тууж" ба "Жангар"-ын доторхи баатрыг харьцуулж үзвэл, "Гэсэрийн тууж"-д гардаг Гэсэр баатар бол ганц биеэр дайсны газар довтлон орж дайн байлдаан хийж, хатуу дайсанд мятрахгүй, хүчир гачигт ноорохгүй хатан баатар зориг сөстэйгээр эрэлхэглэн байлдаж байдаг. Нэн ялангуяа арван хоёр толгойт мангасыг алж, харьу ирсний дараа нуур хөдөө мэт их найр хийж, үхэрчин хоньчингүй бүгдэд нь хишиг буянаа өгч олон бүгдээрээ баяр хөөртэйгээр найрладаг байна. Энэ нь мөнч? Ард олныг хайрладаг эрхэм дээд эгэл доордын ялгаа хараахан биеллээ олоогүй цаг үеийн тусгал болно.

Туужийн агуулгаас нь үзвэл балар эртний үеийн овог аймгийн хоорондох дайн байлдаан эсхүл овог аймгийн зарим нэгэн гишүүний хоорондох тэмцлийг тусгасан байна. "Жангар" бол "Гэсэр"-тэй баахан адилгүй дүрээр илэрдэг. Тэр өөрийн биеэрээ дайн байлдаанд оролцохгүй баатар жанжнаа захирсан нэгэн удирдагчийн дүрээр илэрдэг. Үүнээс үзвэл "Жангар" бол сүүлчийн үеийн бүтээл болох болбуу гэж бодогдуулмаар юм.

"Ойрад Гэсэрийн тууж"-ийн "Шар голын гурван хааны бүлэг"-т цагаан гэртэй хаан, хар гэртэй хаан, шар гэртэй хаан гэж гардаг. Буриадын "Авай Гэсэр хөвгүүн"-д "Гэсэрийн шар голын гурван хаачуулыг дарсан тухай" гэх бүлэг байдаг бөгөөд энэ гурван хаачуул цагаан гэрэл хаан, шар гэрэл хаан, хар гэрэл хаан гэж гардаг бөгөөд "Авай" гэдэг үг нь Ойрад үгэнд настай аав ээжийн хүндэтгэлийн утгатай дуудлага болно.

"Авай" гэх үг Түрк гаралтай бөгөөд эцгүүд буюу өвгөд гэсэн утгатай үг болно. Үүнээс үзэхэд "Авай Гэсэр" гэдэг нь "өвөг дээдсийн Гэсэр" гэсэн утгатай бөгөөд өвөг дээдсээс уламжилж ирсэн эртний бүтээл гэсэн санааг дамаар гаргаж байгаа юм. Бас "Жангар"-ын туульд "хэлмэрч Хэ жалган шар голын гурван хаан лугаа заргацсан бүлэг" гэж байдаг.

Эдгээр бүлгүүдэд адил төстэй агуулга үйл явдлыг давтан дүрсэлсэнээс үзвэл "Жангар"-ын тууль нь "Гэсэрийн тууж"-ийн нөлөө тусгалыг хүртсэн мэт. Үүнд шар гэрт хаан гэдэг нь эртний Монголын өндөрлөгт амьдарч байсан Шар Уйгур, хар гэрт хаан гэдэг нь эртний Хэрэйд аймаг буюу Хар Татаар, эсхүл Тангад, цагаан гэрт хаан гэдэг нь Монгол ястны нэгэн овог аймгийг зааж хэлсэн бололтой. Учир нь эдгээр овог аймаг үндэстэн ястнууд эртдээ бүр Монголын өндөрлөг дээр аж төрөн амьдарч өнгөрсөн түүхтэй бөгөөд тэд харилцаг дайн байлдаан хийж, харилцан ургийн холбоо байгуулж, харилцан утга соёлоо солилцсоны дүнд иймэрхүү адил төстэй зүйлс буй болсон байна. Үнэндээ эл үндэстэн ястнууд түүхэнд адил төстэй цаг үе, орчин тойрон,

ахуй амьдралыг өнгөрүүлсэн тул Уйгур, Төвд, Монгол, Хасаг зэрэг үндэстний дотор иймэрхүү адил төстэй сэтгэхүй буюу үлгэрүүдийг буй болгосны гол шалтгаан болно.

Ардын үгэнд "Гэрээ мартсан Гэсэр", "Энд тэнд явж олон юм үзэж явах"-ыг "Гэсэр болжээ" гэх хэллэгүүд нь эртний монголчуудын хүч чадалтай хүмүүс болох эрэгтэйчүүд нь агуй сууц, хүрээ бууц нутаг уснаасаа салж урт хугацаагаар гэр бүл, эхнэр хүүхдээ гэр нутагтаа хаяж алс хол ан гөрөө буюу аян дайнд оролцож явсан түүхт үйл явдалд суурилагдаж зохиогдсон байна.

Хураангуйлж хэлбэл, "Гэсэрийн тууж"-д эртний Монголчуудын нийгмийн амьдрал, хүн төрөлхтний балчир бага үеийн үзэл санаа жич бөөгийн шашны нөлөө тусгал зохих хэмжээгээр шингэн нэвтэрснээс үзэхэд, "Гэсэрийн тууж" бараг овог төрлийн нийгмийн сүүлчийн үед үссвэртэй ардын аман бүтээл бололтой.

Үндэстнүүдийн уран зохиолын түүх бүр тус үндэстний ард түмний амьдрал тэмцлийн түүхтэй салшгүй холбоотой байхаар үл барам тус үндэстний нийгмийн түүхийн бодот байдлыг тусгасан байдаг. уран зохиолын нэг бүрэлдэхүүн болох "Гэсэрийн тууж" ч мөн иймэрхүү онцлогтой. Иймээс "Гэсэрийн тууж"-д тусгагдсан тухайн нийгмийн түүхэн байдал ба ахуй амьдрал, овор аймгийн хоорондох дайн байлдаан нь ман үнэн бодтой бөгөөд маш боловсон ахуйгаар сүвэгчээ болгож гол үзэл санаа жич зөв буруу хоёр этгээдийн дүрийн нүдэнд үзэгдмээр гарт баригдмаар амилуулан бүтээсэн байна.

Тууж хэдийгээр уламжлагдах явцдаа адил бус шат үе давхаргатны халан өөрчлөлт ба бурханы шашин (улааны ба шарын шашин)-ы үнэр амт өнгө будагт бялтагтсан боловч шашны назгай тал нь "Гэсэрийн тууж"-ийн үзэл санааны гол чиглэлийг гуйвуулж чадсангүй билээ.

Тус туужид илэрсэн тэдгээр бурханы шашны нэрс буюу агуулгын ихэнх нь Юан, Мин, Чин гурван төрийн үест бурханы шашин Монгол оронд адил бус хэмжээгээр дэлгэрэхийг дагалдан тэдгээр шашинтан нар "Гэсэрийн тууж"-ийг ашиглаж өөрийн шашнаа сурталчлахын төлөө хар албаар чихэн оруулснаар барахгүй, зарим бөөгийн шашны агуулгыг шарын шашиндаа шингээн оруулж ашигласан зүйлс ч өдий төдий байхыг дамаар харуулж байна. Иймээс "Гэсэрийн тууж" дахь бурханы шашны нөлөө тусгал нь нэг л түүхэн цаг үед шингэн орсон зүйл биш, харин аль эртнээс аажим аажмаар шингэн нэвтэрсэн зүйл болно.

"Гэсэрийн тууж" дахь төлгө үзэх, тэнгэр тахих, гал шүтэх, сүнс шүтэх, зүүд манах зэрэг үзэгдэл бол монголчуудын эрт язгуурын удамшилт шашин-бөөгийн шашны гол агуулгууд бөгөөд "Гэсэрийн тууж"-ийн буй болохыг дагалдан шингэн нэвтэрсэн зүйлс болно. Энэ бүхнээс үзвэл, "Гэсэрийн тууж" 1640 оноос өмнө биеллээ олж төлөвшсөн байх ёстой. Тухайлбал, 12-р зууны өмнө буй болж, 13-р зууны үеэс 16-р зууны эх болтолх уужимхан хугацаанд төлөвшсөн бүтээл гэж үзэх бололцоотой юм.

